



МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ
ТБАГУТУГ-ЫН ЗАХИРАЛ Н.ОЮУНТЭГШ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/310
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Монгол төрийн түүхийн музейн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол төрийн түүхийн музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Khareg\Yawsan_Bichig\2017\0223SAG15.Docx

УХА0122

070559



“МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ” УТҮГ ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

Санхүүгийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор:
Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Ахлах аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512

Хаяг: Сүлд-Аудит ХХК
Байршил: Сүхбаатар дүүрэг,
8-р хороо, 11-р хороолол,
Жи-Би центр 502 тоот
Утас: 70118016
Цахим хаяг: info@suld-audit.mn
Цахим хуудас:
<http://www.suld-audit.mn/>

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын тайлан

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

2017 оны 2 дугаар сарын 20

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.3 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд “Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/28/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн хооронд хийхээр төлөвлөн Сүлд-Аудит ХХК-ийн аудитор Б.Долгорсүрэн, туслах аудитор А.Одонтуяа нар хэрэгжүүлж, ахлах аудитор Ч.Гүндбаяр, аудитор/чанарын хяналт С.Лхагважав нар хянаж дуусгавар болгож хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Сүлд-Аудит ХХК аудитыг 2017 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс 2017 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 20-нд “Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын захирал нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Соёлын өвийг хамгаалах” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Монгол төрийн түүхийн музей нь Их Монгол Улс байгуулагдсны

800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх үндэсний хорооны шууд залгамж болж Төрийн ордны Ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборын доод танхимд байгуулагдсан байна.

Монгол төрийн түүхийн музейн байр ашиглалт, үйл ажиллагааны чиглэлийг харгалзан 2012 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын 3 дугаар тогтоол гарч тус музей нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын харъяанд шилжин оржээ. Ингэснээр тус музей нь төрийн ёслол үйлчилгээний салшгүй хэсэг болж гадаад дотоодын дипломат төлөөлөгчдөд үйлчлэхийн зэрэгцээ энгийн ард иргэдэд нээлттэй үйлчлэх монголын анхны үнэ төлбөргүй музей болсон байна.

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ нь “Монголын үе үеийн урчуудын урлахуйн их эрдэм ухаанаар туурвин бүтээгдэж, он цагийн шалгарлыг даван хадгалагдаж үлдсэн монгол төрийн түүхэнд холбогдох дурсгалуудыг бүртгэн цуглуулж, унаган төрхөөр нь хадгалан хамгаалж, ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх, улмаар монголын төрт ёсны түүхэн уламжлалыг дэлхий дахинаа сурталчлан таниулах” эрхэм зорилттой билээ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу “Засгийн газрын хэрэг эрхлэх газрын” тэргүүн дэд дарга Шилаагардийн Солонго нь Төсвийн захирагчийн үүргийг, Норовцэрэнгийн Оюунтэгш нь захирлын үүргийг тус тус гүйцэтгэж байна.

Тус байгууллагын 2016 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Ёслол хүндэтгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, бусад хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох журам, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын захиргааны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав. Аудитаар Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа./ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 15-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Монгол төрийн түүхийн музей ТБАГУТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТҮГ-ын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Accolous” программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдлын түвшин:

2016.12.31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдээр аудитын рискийн хэмжээ болон материаллагийн түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийн нөлөөллийг урьдчилан үнэлж, цэвэр хөрөнгийн 536,773.1 мянган төгрөгийг материаллаг байдлын суурь болгон түүний 1 хувиар тооцож, материаллаг байдлын хэмжээг 5,367.7 мянган төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлээр материаллаг байдлыг дахин хянаж үзэхэд өөрчлөлт орсонгүй.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Монгол төрийн түүхийн музей ТБАГУТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад тус байгууллага нь дотоод хяналтын мэргэжилтэнтэй, санхүүгийн мэдээллийг байгууллагын удирдлагаас цаг тухайд нь тогтмол хянаж, зөрчил, хэлбэлзлийн талаар холбогдох арга хэмжээ авдаг байна. Иймээс дотоод хяналт сайн тавигддаг гэж үзээд эрсдэлийг бага гэж дүгнэв.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Сангийн Яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

2016 онд тус байгууллагад улсын төсвөөс 209,561.4 мянган төгрөгийн төсөв батлагдан олгогдсон байна. Урсгал зардалд 209,561.4 мянган төгрөг батлагдсанаас 184,821.4 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвийг 24,740.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Энэ хуулийг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж заасныг үндэслэн хуулийн хэрэгжилтийг шалган үзэхэд “Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан болон 2017 оны батлагдсан төсвийг <http://www.shilendans.gov.mn/> сайтанд байршуулсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд , түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс тус бүрээр нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал:

2016.12.31-ний өдрөөр тайлагнасан санхүүгийн байдлын тайланд 6.1 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний авлага/өглөг, бараа материал, үндсэн хөрөнгө, төсвийн урсгал зардлын санхүүжилт, цалин хөлс, шуудан холбоо, тэтгэмж урамшуулал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 6.1 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн: Менежментийн захидалд зөвлөмжөөр тусгав.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдах боломжгүй алдаа дутагдал илрээгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

“Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

“Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 6.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Илэрсэн 6.1 сая төгрөгийн зөрчил нь тоон утгын хувьд материаллаг боловч тухайн тайлант хугацааны санхүүгийн тайланд нөлөөлөх нөлөөллийн хувьд материаллаг бус шинж чанартай гэж үзэв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй бөгөөд 2014 оны санхүүгийн тайланд Санхүүч-Аудит ХХК-ийн хийсэн аудитаар 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд зөвлөмж одоог болтол хэрэгжээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн шударга илэрхийлсэн байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Огноо: 2017.02.20

АУДИТЫН МЕНЕЖЕР

Я.САМБУУНЯМ

Огноо: 2017.02.20

АХЛАХ АУДИТОР

Б.СЭРЖМЯДАГ

Огноо: 2017.02.20

БЭЛТГЭСЭН:

ТУСЛАХ АУДИТОР

А.ОДОНТУЯА

Огноо 2017.02.16

АНХАН ШАТАНД
ХЯНАСАН АУДИТОР

Б. ДОЛГОРСҮРЭН

Огноо 2017.02.16

ХОЁР ДАХЬ ШАТАНД
ХЯНАЛТ ХИЙСЭН

АУДИТОР/ЧАНАРЫН
ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР

С.ЛХАГВАЖАВ

Огноо 2017.02.16

ДЭЭД ШАТАНД ХЯНАСАН
АХЛАХ АУДИТОР

Ч.ГҮНДБАЯР

Огноо 2017.02.16

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ ТБАГУТУГ-ЫН
ЗАХИРАЛ Н.ОЮУНТЭГШ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол төрийн түүхийн музей ТБАГУТУГ-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

“МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ” ТБАГУТУГ

*2016 оны жилийн эцсийн
санхүүгийн тайлан*

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1

Он дамжсан авлагын
талаар.....13

**2010 оны 3 дугаар
сарын 01**

2017 оны 02 дугаар сарын 20

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг “Монгол төрийн түүхийн музей” ТБАГУТУГ-ын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогч Д.Цэцэгмаа болон бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Он дамжсан авлагын талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016.12.31-ний өдрөөр тайлагнасан санхүүгийн байдлын тайланд 6.1 сая төгрөгийн авлагатай тайлагнагдсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл “6.4.8.төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалтыг зөрчиж байна.

ҮАГ-ын зөвлөмж

Он дамжсан авлагын асуудлыг дараагийн онд багтаан холбогдох дээд байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх

Эрсдэлүүд

Холбогдох хууль журам зөрчигдсөн байх,
(Эрх ба үүрэг, оршин байх)

Төсвийн захирагчийн хариу

Музейн ашиглалтын өмнөх захиргаа 2007 онд байгуулагдахаас өмнө буюу 2006 онд байгуулсан музейн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийн гэрээгээр 6.1 сая төгрөгийн авлага үүссэн бөгөөд энэхүү авлагыг барагдуулахаар музейгээс шүүхэд хандсан ч гэрээний эх хувь нь захиалагч болох Төр, засгийн Үйлчилгээ эрхлэх газрын архивт хадгалагдаагүй учраас шүүхээс буцаасан. УБЕГ-аас өгсөн хаяг дээрээ Оргилсофт ХХК байхгүй болсон.

"МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ" ТБАГУТУГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2015.12.31	2016.12.31
А.ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	254,000.00
Кассанд байгаа бэлэн мөнгө		254,000.00
Авлага	6,197,400.00	6,197,400.00
Төлбөртэй үйлчилгээний авлага	6,197,400.00	6,197,400.00
Урьдчилж төлсөн төлбөр	-	4,265,000.00
Урьдчилж гарсан зардал		4,265,000.00
Бараа материал	46,774,594.50	51,642,714.50
Түүхий эд материал		666,000.00
Хангамжийн материал	46,774,594.50	50,976,714.50
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	52,971,994.50	62,359,114.50
Биет хөрөнгө	483,801,157.41	455,950,753.55
Авто тээврийн хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(6,276,929.64)	(6,500,000.00)
Машин, тоног төхөөрөмж	31,432,405.00	32,132,405.00
Хуримтлагдсан элэгдэл	(9,395,109.22)	(22,098,059.42)
Тавилга, аж ахуйн эд хогшил	62,949,560.00	68,174,560.00
Хуримтлагдсан элэгдэл	(42,686,361.74)	(55,325,089.20)
Түүхийн дурсгалт зүйлс	427,916,160.85	427,916,160.85
Номын фонд	8,682,096.00	8,682,096.00
Бусад үндсэн хөрөнгө	129,971,307.24	129,971,307.24
Хуримтлагдсан элэгдэл	(125,291,971.08)	(133,502,626.92)
Биет бус хөрөнгө	-	550,000.06
Программ хангамж	40,896,640.00	41,776,640.00
Хасагдуулга	(40,896,640.00)	(41,226,639.94)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	483,801,157.41	456,500,753.61
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	<u>536,773,151.91</u>	<u>518,859,868.11</u>
Б. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
Засгийн газрын оруулсан капитал	742,060,566.40	742,060,566.40
Өмнөх үеийн үр дүн	(209,563,680.88)	(209,563,680.88)
Тайлант үеийн үр дүн		(17,913,283.80)
Дахин үнэлгээний зөрүү	4,276,266.39	4,276,266.39
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	536,773,151.91	518,859,868.11
ӨР ТӨЛБӨР БА, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	536,773,151.91	518,859,868.11

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

"МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ" ТБАГУТУГ
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

ҮЗҮҮЛЭЛТ	2016.12.31
ООНЕАИÆ, НАИО —ÆЕӨӨЕЕІ ІӨЕІАІ	
Оёһуі о°һа°һ	201,012,200.00
Одһааё	201,012,200.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	
—ЕЕ АÆЕЕЕААААІУ ІӨЕІАІ А І (I)	201,012,200.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	201,299,534.79
АÆЕЕЕАА×ЕАӨАЕ ОІЕАІААНІІ ÇАӨАÆ	147,379,558.18
Оæеі, о°еһ аіеі іуіуāуё о᠔᠗іөеё	131,201,447.15
Оæеі	100,980,429.15
Нэмэгдэл цалин	20,148,018.00
Оіаа хоолны хөнгөлөлт	10,073,000.00
Іеёāіеёі о᠗іāāāеёуі өеі᠔āуё	16,178,111.03
Оү᠔āуāу᠔ аіеіі оү᠔āуіæеёі өеі᠔āуё	13,497,387.57
Оү᠔āуā᠔еёі āā᠗᠔āāеуі өеі᠔āуё	10,805,911.11
Оү᠔āуіæеёі āā᠗᠔āāеуі өеі᠔āуё	1,083,041.58
—ІІӨ °а÷іеё āā᠗᠔āāеуі өеі᠔āуё	1,340,362.73
Аæеёāçéæеёі āā᠗᠔āāеуі өеі᠔āуё	268,072.15
Ү᠔ççё іуіāеёі āā᠗᠔āāеуі о᠔᠔āāіæ	2,680,723.46
Хангамж, бараа материалын зардал	2,413,022.81
Аё÷еā оү᠔āеёі іā᠗ā᠔еāё	1,377,210.00
Оууāу᠔, өā᠔ā᠔᠔᠔᠔іу çā᠔āāё	413,040.01
Ө᠔᠔āāі өіеāīіу çā᠔āāё	622,772.80
Эд хогшил, урсгал засварын зардал	4,876,150.00
Урсгал засвар	4,876,150.00
Томилолт,зочны зардал	284,500.00
Гадаад томилолтын зардал	38,500.00
Дотоод томилолтын зардал	246,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	12,240,900.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	12,000,000.00
Мэдээлэл технологийн үйлчилгээний хөлс	240,900.00
Бараа үйлчилгээний бусад зардал	34,105,403.80
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,105,403.80
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,625,949.01
Бусад урсгал шилжүүлэг	1,575,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,575,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,050,949.01
Төвлөрүүлэх шилжүүлэг	16,050,949.01
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	218,925,483.80
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(17,913,283.80)
—ЕЕ АÆЕЕЕААААІУ АОН ІӨЕІАІ	
—ЕЕ АÆЕЕЕААААІУ АОН ÇАӨАÆ	
—ЕЕ АÆЕЕЕААААІУ ІЕЕӨ —Ө А І	(17,913,283.80)

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ УТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

<u>Үзүүлэлт</u>	<u>Засгийн газрын оруулсан капитал</u>	<u>Дахин үнэлгээний нөөц</u>	<u>Хуримтлагдсан ашиг</u>	<u>Нийт дүн</u>
2015 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлангийн үеийн үр дүн				
2015 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.39	(209,563,680.88)	536,773,151.91
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.39	(209,563,680.88)	536,773,151.91
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлангийн үеийн үр дүн			(17,913,283.80)	(17,913,283.80)
2016 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	742,060,566.40	4,276,266.39	(227,476,964.68)	518,859,868.11

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ" ТБАГУТҮГ
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

ҮЗҮҮЛЭЛТ	/төгөрөөр/ 2016.12.31
Ооһөаiaæ, һайдогчæеёдуй idейai	
Оёнуй о°һа°н	
Одһаә	201,012,200.00
ЕЕ АÆЕЕЕААААИУ I°IA°I IDEIAUI A T (I)	201,012,200.00
Бараа ажил үйлчилгээний зардал	176,327,250.99
Aæeëeaä-eaðae õieáíaañii çaðaaë	147,379,558.18
Öæei, o°en áiei iýiyääyë oðaiøee	132,756,158.11
Öæei	112,433,558.18
Áoñaä iýiyääëççä	5,631,000.00
Óìàà, õïieiü ò°íä°e°èð	14,691,600.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,623,400.00
Òyòäyãðeéí àààðääeúí øèìðäyë	10,756,400.00
Òyòäyiæeéí àààðääeúí øèìðäyë	773,600.00
TlØ °ä-ièé àààðääeúí øèìðäyë	967,000.00
Àæeëäçéæeéí àààðääeúí øèìðäyë	193,600.00
Ýðççë iýiæeéí àààðääeúí óððaaîæ	1,932,800.00
Aaðaa çéë-eëäyúiéë oðñaä çaðaaë	29,647,692.81
Хангамж, бараа материалын зардал	2,378,112.81
Äe-eä öyðæeéí çaðaaë	676,300.00
Ôyyäyð, øàðàðóóíú çaðaaë	1,079,040.01
Øóóaaí, õieáiñíú çaðaaë	622,772.80
Нормативт зардал	2,195,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,195,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	10,991,080.00
Багаж техник хэрэгсэл	726,700.00
Урсгал засвар	10,264,380.00
Томилолт, зочны зардал	246,000.00
Дотоод албан томилолт	246,000.00
Aónåààð äçéöyðäççëñuí àæeë çéë-eëäyú	13,137,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	1,000,000.00
Даатгалын үйлчилгээ	12,000,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	137,500.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,625,949.01
Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,050,949.01
Засгийн газрын дотоод шилжүүлэг	16,050,949.01
Бусад урсгал шилжүүлэг	1,575,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,575,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	193,953,200.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,059,000.00
O°ð°íæeéí ideiai	
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал	6,805,000.00
Хөрөнгийн бусад зардал	
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН	6,805,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,805,000.00)
NAIO AEEI EE AE EEEAAAIIU ЦЭВЭР I°IA°I A EEAYY	
IIEO OYAÜÐ I°IA°I A EEAYY	254,000.00
I°í°, ðççidýe àæeëðääð o°ð°íæeéí yõieë çäyāyāyë	-
I°í°, ðççidýe àæeëðääð o°ð°íæeéí yõñeéí çäyāyāyë	254,000.00

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно

**МОНГОЛ ТӨРИЙН ТҮҮХИЙН МУЗЕЙ ТБАГУТУГ
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
2016 оны 12 дугаар сарын 31-ний өдөр**

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	209,561,400.00	184,821,450.99	24,739,949.01	88.19
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	209,561,400.00	184,821,450.99	24,739,949.01	88.19
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	209,561,400.00	184,821,450.99	24,739,949.01	88.19
Бараа, үйлчилгээний зардал	207,561,400.00	183,246,450.99	24,314,949.01	88.29
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	145,027,200.00	132,756,158.18	12,271,041.82	91.54
Үндсэн цалин	129,000,000.00	114,281,058.18	14,718,941.82	88.59
Нэмэгдэл цалин	-	5,119,100.00	(5,119,100.00)	
Унаа, болон бусад нөхөн олговор	16,027,200.00	13,356,000.00	2,671,200.00	83.33
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,952,900.00	14,623,400.00	1,329,500.00	91.67
Тэтгэврийн даатгал	10,151,900.00	10,756,400.00	(604,500.00)	105.95
Тэтгэмжийн даатгал	1,160,200.00	773,600.00	386,600.00	66.68
ҮОМШӨ ний даатгал	1,450,300.00	967,000.00	483,300.00	66.68
Ажилгүйдлийн даатгал	290,000.00	193,600.00	96,400.00	66.76
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	2,900,500.00	1,932,800.00	967,700.00	66.64
Хангамж, бараа материалын зардал	3,182,400.00	2,492,312.81	690,087.19	78.32
Бичиг хэрэг	1,040,400.00	676,300.00	364,100.00	65.00
Тээвэр (шатахуун)	1,428,000.00	1,079,040.01	348,959.99	75.56
Шуудан холбоо, интернетийн төлбөр	714,000.00	736,972.80	(22,972.80)	103.22
Нормативт зардал	2,460,000.00	2,195,000.00	265,000.00	89.23
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,460,000.00	2,195,000.00	265,000.00	89.23
Эд хогшил худалдан авах	23,900,800.00	17,356,080.00	6,544,720.00	72.62
Багаж, техник хэрэгсэл	7,310,000.00	1,866,700.00	5,443,300.00	25.54
Тавилга (Үзмэр худалдаж авах)	12,617,100.00	5,225,000.00	7,392,100.00	41.41
Урсгал засвар	3,973,700.00	10,264,380.00	(6,290,680.00)	258.31
Томилолт, зочны зардал	764,300.00	246,000.00		32.19
Дотоод албан томилолт	764,300.00	246,000.00	518,300.00	32.19
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	14,773,800.00	13,577,500.00	1,196,300.00	91.90
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	-	1,000,000.00	-
Тээврийн хэрэгслийн оношилгоо	183,800.00	-	183,800.00	-
Даатгалын үйлчилгээ	12,000,000.00	12,000,000.00	-	100.00
Мэдээллийн технологийн зардал	590,000.00	577,500.00	12,500.00	97.88
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	-	1,500,000.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	1,575,000.00	425,000.00	78.75
Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	1,575,000.00	425,000.00	78.75
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,000,000.00	1,575,000.00	425,000.00	78.75
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	209,561,400.00	201,012,200.00	8,549,200.00	95.92
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	209,561,400.00	201,012,200.00	8,549,200.00	95.92
Улсын төсвөөс санхүүжих	209,561,400.00	201,012,200.00	8,549,200.00	95.92
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500,000.00	254,000.00	246,000.00	50.80

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно